**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*2022 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар*

| № | ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт<br>2022 он<br>Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв /сая төг/ | Хүрсэн түвшин, үр дүн<br>Хэрэгжилт | Хүрсэн түвшин, үр дүн<br>Гүйцэт-гэл /сая төг/ | Хэрэг жилт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.5. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ** | | | | | | | | | |
| | 2.3.1. Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2 нас, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | 2. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | | Хамрагдах хүүхдийн тоог 2020 оны түвшнээс 26.0 хувиар нэмэгдүүлсэн байна | Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангахад 2.1 тэрбум төгрөг батлагдсан. | МУЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 97 тоот тогтоолоор “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох” журам, ХНХ-ын сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/38 тоот тушаалаар “Хүүхэд харагч бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр”, ХНХ-ын сайдын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/151 дугаар “Журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам” шинэчлэн батлагдсан.<br>Монгол Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд хүүхэд харах үйлчилгээний зардалд 2.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад батлагдсан бөгөөд энэ хүрээнд 2022 онд 1894 хүүхэд (үүнээс 106 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд) тус үйлчилгээнд хамрагдах тооцооллыг хийсэн.<br>Хүүхэд харах үйлчилгээг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс эхлүүлж, улсын хэмжээнд 16 аймаг, 7 дүүрэгт 176 хүүхэд харах төвд 470 хүүхэд харагч ажиллаж, хамрагдсан нийт хүүхдийн дундаж 2200 байна.<br>2/“Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын 6 дахь заалтын хэрэгжилтийг | 1.3 тб төг | **90** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хангах хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны А/145, А/261 дугаар хамтарсан тушаал баталж, нийслэлийн цэцэрлэгийн хүртээмж багатай Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, 2-3 настай 2000 хүүхдийг нэмж авахаар шийдвэрлэсэн. Шинээр 320 хүүхэд харагч 5 өдрийн сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн.<br>-2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хүүхэд харах үйлчилгээнд нийт 2239 хүүхэд үйлчлүүлж, Хүүхэд харах үйлчилгээний төв болон цэцэрлэгийн хүүхдийн давхардлыг шалган 303.460.806.4 төгрөгийн санхүүжилтийг төвүүдэд олгосон.<br>Үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар арга зүйн дэмжлэг үзүүлж 10 зөрчил илрүүлж асуудлыг шийдсэн. | | |
| | 2.3.5. Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ. | | 2. Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, нэн хэрэгцээтэй хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа, мэдээлэлд үндэслэн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэнэ. | | Улс орны хөгжлийн шаардлагатай уялдуулан мэргэжилтэн бэлтгэх чиглэлийг уян хатан болгосон байна. | | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/473, А/221 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Улаанбаатар хот болон орон нутаг дахь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлынг хүрээнд шилжүүлэн, хүлээлгэн өгсөн болно. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам нь зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн богино хугацааны мэргэшүүлэх сургалтын бодлого хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | **50** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2.5.1.Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ | 1 | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх | 2020-2024 | Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна | - | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.<br>Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн болович Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл нь одоо мөрдөгдөж буй эв санааны нэгдлээс хуримтлалын тогтолцоонд шилжих, нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх, мөн санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх зэрэг зарчимд үндэслэн боловсруулж, шинэчлэлийн асуудлыг тусгав. | | 90 |
| | | 2 | Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ | 2020-2024 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсан байна. | - | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн. | | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Үзэл баримтлалын төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцооны харилцааг хуулийн төслийн 2 дугаар бүлгээр зохицуулахаар тусгасан болно. | | |
| | | 3 | Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ | 2020-2024 | Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хууль батлагдсан байна. | - | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, хуулийн төслийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. Хуулийн төсөл нь 11 бүлэг, 60 зүйлтэй бөгөөд дагалдуулан 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. | | 90 |
| 2 | 2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ | 1 | Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчны хүрээнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ | 2020 2024 | Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх талаарх хуулийн заалт батлагдсан байна. | - | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.<br><br>Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл | | **90** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Үзэл баримтлалын төсөлд өвлүүлэх харилцааг хуулийн төслийн 3 дугаар бүлгээр зохицуулахаар тусгав. | | |
| **3** | 2.5.3. Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ. | 1 | Хуримтлалын нэгдсэн сан бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | 2020<br>2022 | Хуулийн төслийг батлуулж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. | 20.0 | Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьчилан тандсан судалсан тухай тухай тайланг боловсруулж дуусав.<br>Голланд, Сингапур, Казахстан, Норвеги, Чили зэрэг тэтгэврийн хуримтлалын тогтолцоотой орнуудыг сонгон авч судлав.<br>Сингапур улсын Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийг орчуулж судалгаанд ашиглаж эхлэв.<br>Бүгд Найрамдах Сингапур Улсын Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2021 оноос хойш удаа дараа харилцан санал солилцож, хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Сингапур Улсад хийсэн айлчлалын хүрээнд 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай хамтран ажиллах санамж бичгийг гурван (3) жилийн хугацаатай байгуулав.<br>Монгол Улсад Хуримтлалын нэгдсэн сан бий болгоход дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврыг боловсруулж Дэлхийн банкинд хүргүүлж батлуулсан. Энэхүү техникийн нөхцөлийн дагуу Сингапураас авах зөвлөх үйлчилгээний 1 ба 2 шатны тодорхой хэсгийг Дэлхийн банкнаас Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан гэрээгээр санхүүжүүлэхээр болов.<br>Хуримтлалын нэгдсэн сантай хамтран ажиллах чиг үүрэг бүхий Удирдах хороог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/153, уг Удирдах хорооны ажилд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/144 дүгээр тушаалаар батлуулав.<br>2022 оны 8 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний 5 хүний бүрэлдэхүүнтэй баг | | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монгол Улсад ажиллав. Зүүн өмнөд Азийн газрын захирал ноён Тан По Тек, Сингапурын Хуримтлалын нэгдсэн сангийн ТУЗ-ийн гишүүн Юу Ёон Кан Дон, Со Чен Хэн, менежер Чиа Зао Рү, зөвлөх Лим Чи Киа нарын төлөөлөгчид Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яамны удирдлагуудтай албаны уулзалт хийж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харьяа агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс зэрэг байгууллагуудад ажиллаж, үйл ажиллагаатай танилцав.<br>Сингапур Улсад Хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоог бий болгож, хөгжүүлсэн туршлагаас хуваалцах сургалтыг 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний баг зохион байгуулав. Уг сургалтад холбогдох яамд, агентлаг, төрийн бус байгууллага, судлаачдын 100 гаруй төлөөлөл оролцов.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний багаас эхний шатны ажлын тайланг хүлээн авав.<br>2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй ажлын хэсэг тайланг хэлэлцэх цахим хурлыг Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний багтай зохион байгуулж санал солилцов. Тус хуралд Сингапурын зөвлөх үйлчилгээний багийн Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын Ойрхи дорнод, хойд азийг хариуцсан захирал Тан По Тек, ахлах зөвлөх Сох Чин Хэнг, зөвлөх Каролин Чиа нар оролцож улмаар тайланг нэмж сайжруулан Сингапурын зөвлөх үйлчилгээний багаас дахин ирүүлэхээр болов. | | |
| 4 | 2.5.4.Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан | 1 | Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн | 2020-2024 | Хуулийн шинэчлэлтэй уялдуулан холбогдох бусад хууль тогтоомж, бусад дүрэм, журамд өөрчлөлт оруулж батлуулсан байна. | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, ниймийн хамгааллын сайдын 2020 оны А/162 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцоо, судалгаа бусад баримт бичгийн хамт боловсруулж, төлөвлөгөөний дагуу 2022 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | | **70** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | | тогтолцоог нэвтрүүлнэ | | | - | Хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хуулийн бичвэр томьёоллыг боловсруулж, хөдөлмөрийн салбарын ажилтнуудын төлөөллүүдээс санал авах ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 4-8-ны өдрүүдэд зохион байгуулав. Энэ ажилд давхардсан тоогоор нийт 40 гаруй албан тушаалтан оролцож, 50 гаруй санал гарган, хуулийн бичвэрийн хэсэгт саналуудыг тусган дахин боловсруулав.<br>Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулиар зохицуулах харилцаа болон хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнүүдийн уялдааны талаар танилцуулах, санал солилцох уулзалтыг 2022 оны 03 дугаар сард зохион байгуулав. Уулзалтад тус яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Сангийн яам, НҮБХХ-ийн төлөөлөл оролцлоо.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг 2011 онд шинэчлэн найруулсанаас хойш 2015 онд Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай болон Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181, 88 дугаар конвенцыг Монгол Улсын Их Хурал соёрхон баталж, нэгдэн орсон. Улмаар конвенцуудын үзэл санаа, зүйл заалтыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт зорилтот бүлгийн иргэдэд тодорхой хэмжээнд дэмжлэг болж байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтэд дорвитой эерэг өөрчлөлтийг бий болгож чадахгүй байгаа тул “Халамжаас хөдөлмөрт” гэсэн зарчимд үндэслэн тус хуулийн хүрээнд зохион байгуулагддаг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр, арга хэмжээ, үйлчилгээг орчин үеийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнг сайжруулах зохицуулалтуудыг тусгалаа.<br>Түүнчлэн ХЭДС-гийн үйл ажиллагааг тогтвортой, хүртээмжтэй, үр дүнтэй явуулах зорилгоор сангийн орлогыг гадаадын ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийн орлогоос шууд хамааралтай байгааг өөрчилж, улсын төсвөөс хуваарилах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, Ажилгүйдлийн даатгалын сан болон бусад | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох сантай уялдуулах зэрэг зохицуулалтыг хуульд тусгасан.<br>Мөн уг сангаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг байнгын ажлын байр бий болгоход түлхүү чиглүүлж, үр шим хүртэгчдэд ногдох санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд тусган, хөтөлбөр, арга хэмжээнүүдийн үр дүнд тавих хяналтыг сайжруулах, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа болон зарцуулалтыг “шилэн, ил тод болгох” механизмыг бий болгох зохицуулалтыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгахаар ажиллаж байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ажил олгогчид санхүүгийн дэмжлэг, урамшуулал олгохоос гадна ажлын байрыг хадгалах, хамгаалах, ялангуяа эдийн засгийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас бий болдог хямралын үед дэмжих арга хэмжээг Ажилгүйдлийн даатгалын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжтой уялдуулан тусгах зохицуулалтыг хийхээр ажиллаж байна.<br>Дээрх асуудлуудаас гадна хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгох хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн ойрын, дунд, хэтийн хугацааны судалгааг холбогдох аргачлалын дагуу хийж, дүн, мэдээг иргэдэд түгээх замаар мэргэжил сонголтыг зөв, оновчтой хийх боломжийг дэмжих зохицуулалтыг тусгах; шинээр болон нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан, мөн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга хийхээр боловсруулж байгаа хуулиудтай уялдуулах; хөгжлийн бэрхшээлтэй хүн болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зохицуулалт хийх, дэмжлэгийн төрөл, хэлбэрийг хуульд нарийвчлан тусгах; бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хүрээнд нэр томьёог боловсронгуй болгож, холбогдох дэмжлэг, урамшууллыг оновчтой, уялдаатай, шаталсан байдлаар тодорхойлох, бизнес инкубацын үйлчилгээг орчин үеийн чиг хандлагад нийцүүлж үзүүлэх зэрэг дэмжлэг, үйл ажиллагааг хуульд тусган боловсруулж байна. | | |
| | | 2 | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний уян | 2020-2024 | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний үйл | | Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний зөвшөөрөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хатан зохицуулалт бий болгож, бүтээн байгуулалт, хөдөлмөрийн зах зээлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ | | ажиллагаанд цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна. | - | шилжүүлэх ажлыг 2020 онд эхлүүлж, цахим системийн хөгжүүлэлт хийгдэн, ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор ezuvshuurul.mn цахим хаяганд төвлөрүүлэн бүрэн ашиглалтад оруулан ажиллаж байна. Цахим шилжилттэй холбогдуулан шаардагдах дүрэм журмыг батлуулж, иргэд, аж ахуйн нэгжээс цахим системээр дамжуулан бичиг баримтыг хүлээн авч шийдвэрлэж байна. Мөн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний мэдээллийн сан үүсгэн, холбогдох мэдээ, мэдээллийг цаг алдахгүй цахим системд байршуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна.<br>Дээрх ажлын хүрээнд:<br>-“Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 3.3, 3.4, 3.5, 3.6-д заасан үйлчилгээг 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ezuvshuurul системээр дамжуулан цахим хэлбэрээр үзүүлж байна.<br>-“Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгох“ үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, ezuvshuurul.mn/out цахим систем хөгжүүлэн бүрэн ашиглалтад оруулаад байна. Уг системд 68 тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй бөгөөд 2287 зуучлуулагч иргэн бүртгэлтэй байна.<br>-Ezuvshuurul.mn цахим систем нь ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой үйлчилгээг үзүүлэхээс гадна БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн Солонгос хэлний шалгалтын бүртгэлтэй холбоотой мэдээллийг цахимаар хүргэн ажиллах юм.<br>Улсын Их Хурлаар 2001 онд батлагдсан “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль”-ийг шинэчлэн найруулж “Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай” хууль нэрээр Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Уг хууль нь 2022 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс цахим системд нэмэлт хөгжүүлэлт, засвар үйлчилгээ хийгдэж байна.<br>Гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах үйлчилгээний цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийх, засвар үйлчилгээний гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулахаар ажиллаж байна. Гэрээлсэн мөнгөн дүн 19.600.000 төгрөг болно. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дараах ажлыг хийхээр төлөвлөж, ажлын даалгаврыг боловсруулж байна. Үүнд:<br>-Гадаадад гаргах тусгай зөвшөөрлийн үйлчилгээний цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, засвар үйлчилгээ хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж байна. Ажлын даалгаварын дагуу гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулж, нэмэлт хөгжүүлэлт хийгдэнэ.<br>-Япон улсад ур чадвартай ажилтнаар илгээх цахим системийг нэвтрүүлж ezuvshuurul.mn хаяганд нэгтгэхээр төлөвлөж, ажлын даалгаварыг боловсруулж байна. Уг системийг гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулна. | | |
| | | 3 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах | 2021-2024 | Урамшууллын ажлын үр дүнтэй уялдуулах аргачлалыг нэвтрүүлж, холбогдох журмыг хэрэгжүүлнэ. | - | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Боловсрол, шинжлэх ухааны яам хамтран боловсролын салбарын зарим төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанар үр дүнг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах аргачлал бий болгох, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх ажлыг 2021 оны 6 дугаар сараас эхлүүлсэн. Боловсролын салбарын удирдах болон гүйцэтгэх түвшний холбогдох албан тушаалтнууд, салбарын Үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүд болон багш, туслах багш зэрэг салбарын бүх түвшний албан хаагчдын төлөөллийг оролцуулсан танилцуулах болон зөвлөлдөх 4 үе шат бүхий сургалт, хэлэлцүүлэг, судалгаа зэргийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Дээрх үе шаттай арга хэмжээний үр дүнд үндэслэн боловсролын салбарт хэрэгжүүлж болох гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцооны схем, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, түүнийг үнэлэх үнэлгээний зааварчилгааны төслийг тус 2 яам хамтран боловсруулж Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.<br>2. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулж төрийн удирдах албан тушаалтнуудыг ажлын үр дүнгээр нь, төрийн гүйцэтгэх албан тушаалтнуудыг гүйцэтгэлээр нь үнэлдэг болгохоор ажиллаж байна. Үр дүнд нь төрийн албаны хариуцлага, бүтээмж дээшилнэ. | | **100** |
| | | 4 | Ажилтны бүтэн бус цагаар, зайнаас, | 2020-2021 | Ажилтны бүтэн бус цагаар, зайнаас | | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ажилтныг ажлын бүтэн бус | | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалт бий болгох | | ажиллах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн онцлог харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн байна | - | цагаар ажиллуулах, гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн онцлог харилцааг зохицуулсан заалтуудыг тусган, УИХ-ын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг эцэслэн баталсан. Тухайлбал: хуулийн 66.1-дэх хэсэгт “Ажлын бүтэн бус цагийн ажилтан гэж ажлын бүтэн цагаар ажиллаж байгаа ажилтнаас бага цагаар ажиллаж байгаа ажилтныг ойлгоно, 86.1 дэх хэсэгт “Ажлын бүтэн бус цагаар ажиллах ажилтны долоо хоногт ажиллах цаг 32-оос илүүгүй байна”, 66.4 дэх хэсэгт “Ажлын бүтэн бус цагийн ажилтан нь бүтэн цагаар ажиллах ажилтны нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх, хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасан нь Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Цагийн ажиллагчдын тухай” 1994 оны 175 дугаар конвенцийн үзэл санаа, зарчим Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д бүрэн тусгагдсан байна. Бүтэн бус цагийн ажилтны цалингийн нэгжийн үнэлгээ ижил ажлын байранд бүтэн цагаар ажилладаг ажилтныхаас багагүй байх, ажилласан цагтаа тохирсон ээлжийн үндсэн болон нэмэгдэл амралт эдлэх эрхийг мөн хуулиар баталгаажуулсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 67 дугаар зүйлд “Гэрээсээ ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ”, 68 дугаар зүйлд “Зайнаас ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ”, 92 дугаар зүйлд “Уртын ээлжээр ажиллуулах” зохицуулалтыг тус тус тусгасан.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар олон нийтэд сурталчлах арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжүүлж байна. | | |
| 5 | 2.5.5. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 1 | Төрийн албан хагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2022-2024 | Цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн байна. | 181.000.0 | Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг урьд нь мөрдөж байсан цалингийн сүлжээний хамгийн өндөр буюу 5 дугаар шатлалаар тогтоосон. Үр дүнд нь төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин дунджаар 8.5 орчим хувиар нэмэгдсэн.<br>Мөн Засгийн газрын 2022 оны 193 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах болон | 155,300.0 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ТЗ-5 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг, төрийн захиргааны албан тушаалын АА-9 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүгчийн туслах болон АА-10 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоосон.<br>Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөвт төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчлэх замаар цалин хөлсийг ажилласан жил, бүтээмж, хүрсэн үр дүнтэй уялдуулан тогтоодог болох, төрийн албан хаагчдын цалин хөлсийг тодорхой хувь хэмжээгээр нэмэгдүүлэх дараах арга хэмжээ тусгагдсан. Үүнд:<br>1. Төрийн албаны цалингийн олон шатлал, зэрэглэлийг цэгцлэн үндсэн цалинг шатлалгүй болгож, төрийн захиргааны 15 зэрэглэлийг 10 болгоно.<br>2. Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлнэ.<br>3. Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах хүрээнд орон нутгийн нэмэгдэл олгоно. Ингэхдээ улсын төсвөөс 20 хувийн нэмэгдлийг олгох ба энэ хэмжээг 100 хүртэл хувьд хүргэх эрхийг орон нутагт нь олгоно.<br>4. Нийт төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дээшлүүлэх хүрээнд тэдний ажилласан жил бүрийг үнэлж нэмэгдэл олгодог болно.<br>5. Төрийн захиргааны албан хаагчдын хариуцлага, ажлын үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн удирдах албан тушаалтнуудыг ажлын үр дүнгээр нь, төрийн гүйцэтгэх албан тушаалтнуудыг гүйцэтгэлээр нь үнэлдэг болно.<br>Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны улсын төсвийн төсөлд нийт 266.2 тэрбум төгрөг тусгагдаад байна. | | |
| | | 2 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг | 2022-2024 | Инфляцын түвшинтэй уялдуулан | | Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн 2021 оны хэрэглээний үнийн индексийн өсөлт (инфляцийн түвшин)-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувьтай байсан. | | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | | тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн байна. | - | Иймээс тэтгэврийн худалдан авах чадварыг хэвээр хадгалах зорилгоор инфляцийн түвшинтэй уялдуулан Засгийн газраас 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа бүх тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөгт, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр шийдвэрлэсэн. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 29.4 хувиар нэмэгдэж 547.2 мянган төгрөгт хүрсэн. | | |
| | 3 | Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооно. | 2020-2024 | Тэтгвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэн, тэтгэврийн зөрүү ойртсон байна. | 539,461.5 | Засгийн газрын 2022 оны 63 дугаар тогтоолоор хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дахин нэмэгдүүллээ. Үүнд:<br>Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар;<br>Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 500 000 (таван зуун мянган) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400.000 (дөрвөн зуун мянган төгрөгөөр);<br>Энэ арга хэмжээний хүрээнд нийт 462.8 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, дундаж тэтгэвэр 549.5 мянган төгрөгт хүрлээ.<br>Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоох зорилгоор тэтгэвэр тогтооход баримтлах цалингийн 2021 он суурьтай, 2023 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжих "Итгэлцүүр батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Үндэсний статистикийн хорооноос авсан. 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/423 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тусгав. Мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс санал авахаар 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 02/1563 тоот албан бичиг хүргүүлсэн.<br>Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсөвт тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтооход шаардлагатай 156.2 тэрбум төгрөгийн зардлыг Нийгмийн даатгалын сангийн 2023 оны | | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төсвийн төсөлд тусган Сангийн яаманд хүргүүлсэн ч батлагдаагүй. | | |
| | | 4 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бүсүүдийн хүн амын амьжиргааны түвшний дундажтай тэнцүү болгож нэмэгдүүлнэ. | 2022-2024 | Тухайн үеийн хүн амын амьжиргааны түвшний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ. | 28,955.0 | Нийгмийн халамжийн тэтгэврийг 63.1 мянган иргэн буюу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг зэрэг хүн амын 5 бүлэгт олгож байна. Мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 11.5 мянган хүүхэд халамжийн тэтгэврийн хэмжээгээр тэтгэмж авдаг. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед орлого багатай, эрсдэлд өртөмхий эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэвэр 188 мянган төгрөгийг 2020 оны 5 дугаар сараас 2021 оныг дуустал нийт 20 сарын хугацаанд 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж олгосон. Засгийн газрын 2022 оны 60 дугаар тогтоолоор энэхүү арга хэмжээг 2022 онд дээрх нэмэгдсэн дүнгээр үргэлжлүүлэн олгож байна. 2022 оны 10 дугаар сарын байдлаар халамжийн сангийн мэдээгээр 60.0 мянган иргэнд 121.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 115.3 мянган иргэнд 68.9 тэрбум төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна. | 76.5 тэрбум төгрөг /үүнээс 100 мянган төгрөгийн нэмэгдэл д 28,9 тэрбум төгрөг/ | 100 Тоон мэдээ засах |
| | | 5 | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчилж, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. | 2022-2024 | ХХДХ-г инфляцын дундаж түвшин, дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэн тогтооно. | 36.0 | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 5 дугаар сарын 4-ний 10 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс сард 550000 төгрөг байхаар шинэчлэн тогтоов. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой төсвөөс гарах холбогдох тооцоо, судалгааг хийж, Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан. | | 100 |
| 6 | 2.5.6.“Цахим Монгол” арга хэмжээний | 1 | Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим | 2020-2024 | Нийгмийн халамжийн үйлчилгээний 60 хувийг цахимжуулсан байна. | 100.0 | Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-д хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-д төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх зорилго, зорилтын хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг хөгжүүлж байна. | | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно. | | хэлбэрт шилжүүлэх | | | | Системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв хамтран хэрэгжүүлж байна. Тус системийг 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлж, 2020 онд 6, 2021 онд 20, 2022 онд 36 төрлийн үйлчилгээг цахимжуулсан бөгөөд одоогийн байдлаар 72 нэр төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг цахимжуулсан байна. Үлдсэн үйлчилгээний хувьд харьяалах яамдад шилжсэн 2 төрлийн үйлчилгээ, холбогдох журам гараагүйн улмаас хэрэгжихгүй байгаа 2 төрлийн үйлчилгээ, цахимжих боломжгүй 3, тусгай програмаар үзүүлж байгаа 1 төрлийн үйлчилгээ тус тус байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 1,2 сая иргэн хамрагдаж, 520.9 тэрбум төгрөг зарцуулна. /хүүхдийн мөнгөн хуримтлалыг тооцохгүйгээр/. Нийт хамрагдсан иргэний 89.8 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар авч байна. Мөн 21 аймаг 330 сум, 9 дүүргийн 204 хороонд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг цахим эрхийн бичиг (банкны карт)-аар үзүүлж байна. “Нийгмийн халамжийн нэгдсэн систем” нэвтэрснээр иргэн нийгмийн халамжид хамрагдах хүсэлтээ төрийн байгууллагад очилгүйгээр нийгмийн халамжийн цахим хуудас болох ehalamj.mn, төрийн үйлчилгээний цахим машин "ТҮЦ машин", ebarimt аппликейшныг ашиглан гаргах, олон байгууллагаар явж цаасаар бүрдүүлдэг баримт бичгийн тоо багасах, өргөдөл, хүсэлтийнхээ шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, өөрийн нэр дээрх арилжааны банкин дахь харилцах дансаараа дамжуулан халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөө авах зэрэг иргэнд ээлтэй олон давуу талууд бий болсон. Нийгмийн халамжийн ажилтан цахим системээр дамжуулан иргэдийн хүсэлтийг хүлээн авдаг болсноор иргэн цаасан материал бүрдүүлж, архивлах зэрэгт зарцуулдаг хугацаа багасч, халамж шаардлагатай иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, гэрээр нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг нийгмийн ажлын үйлчилгээнд илүү хугацаа зарцуулах боломж бүрдлээ. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэнэ. | 2020-2024 | Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулсан байна. | 100.0 | Нийгмийн даатгалын 34-н төрлийн үйлчилгээний 24-н үйлчилгээг нь цахимжуулсан. E-Mongolia цахим системд 12 үйлчилгээг холбосон. E-Mongolia-аас тэтгэвэр тогтоолтын хуудсыг англи хэлээр авах боломжийг бүрдүүлэв. Цахимжуулсан 11 үйлчилгээний хувьд 1 жилд 11.2 тэрбум төгрөг иргэд хэмнэжээ. Үүнд:<br>• Цахим тэтгэврийн дэвтэр<br>• Цахим эмнэлгийн хуудас<br>• Цахим тэтгэмж<br>• Цахим лавлагаа<br>• Цахим гэрээ г.м<br>Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулсанаар дараах ач холбогдолтой байна.<br>-Нийгмийн даатгалын үйлчилгээ ил тод, түргэн шуурхай болох;<br>-Хүнд суртал, чирэгдэл багасч, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх боломж бүрдэх;<br>-Хүнд суртал, чирэгдэл багасч, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх боломж бүрдэх;<br>-Нийгмийн даатгалын ажилтны ачаалал тодорхой хэмжээгээр буурч, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, таниулах ажилд цаг зарцуулах.<br>Үлдсэн үйлчилгээг 2024 он хүртэл үе шаттайгаар цахимжуулах ажлыг зохион байгуулна.<br>-Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ашиглаж байгаа програм хангамжуудыг вэб технологид суурилсан нэгдсэн нэг цогц систем болгон нэвтрүүлэх ажлыг Азийн хөгжлийн банкны төслийн санхүүгийн дэмжлэгээр ITZone компани гүйцэтгэж байна.<br>-2023 оноос шинэ системд бүрэн шилжүүлж нэгдсэн мэдээллийн сангаас үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр зорин ажиллаж байна. | | 100 |
| 3 | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлэх | 2020-2024 | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөр төслийн үйл ажиллагааг нэгтгэсэн байна. | 1.500,0 /ДБ-ны санхүүжилтээр/<br>100.0 | Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг нэвтрүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, дэд ажлын хэсгийг байгуулан харьяа агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд, холбогдох бусад байгууллагын төлөөллийг оролцуулан нийт 32 удаагийн уулзалтыг зохион байгуулж ажилласан байна. | **604.0 ДБ-ны санхүүжилтээр** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Ejob” платформ нь 3 дэд систем, 13 модулиас бүрдсэн. Шинэ систем нь “ХУР”, “ДАН” зэрэг төрийн бусад мэдээллийн системтэй холбогдож, хэрэглэгч бүрийн хэрэгцээнд тохируулан хөгжүүлж, хүндрэл бэрхшээлийг технологийн шийдлээр оновчтой шийдвэрлэхээр зорьсон болно. Уг системийг 21 аймаг, 9 дүүргийн сум, хороодын түвшинд ажил хайгчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын хүний нөөцийн 1 сая гаруй хэрэглэгч ашиглах юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад орууллаа. Системийн нэвтрүүлэлттэй холбоотойгоор Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар болон аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн нийт 301 албан хаагчдыг хамруулсан сургалтыг 2 өдрийн хугацаанд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Одоогийн байдлаар системийн эхний модуль буюу онлайн порталыг ашиглалтад оруулсан бөгөөд ажил хайх, ажил санал болгох үйл ажиллагааг уламжлалт арга барил буюу хувь хүний мэргэжил, боловсролд илүү тулгуурлан зуучилдаг байсан бол шинэ системд ажилд зуучлах алгоритм үүсгэж ажил хайгчдын ажлын туршлага, ур чадвар, чадамжийг харгалзан хүний оролцоогүйгээр системийн тусламжтайгаар ажилд зуучлах давуу талтай болж байна. Өөрөөр хэлбэл, ямар нэгэн боловсролгүй, дипломгүй ч гэсэн ажил хөдөлмөр хийж байсан туршлага, ур чадвартай бол ажилд санал болгох боломжийг нээж өгч байгаа юм. | | |
| 4 | Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Үйлчлүүлэгч төвтэй аргачлал"-ыг нэвтрүүлж, цахимжуулна. | 2020-2024 | Хөдөлмөр зуучлалын цахим программ хангамжийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаатай холбосон байна. | | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Цахим Монгол” арга хэмжээ, Коронавируст халдвар /covid-19/-ын цар тахлын өнөө үед төрийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон хөдөлмөрийн хувийн биржүүд хөдөлмөр зуучлалын үйлчилгээг 2021 оны 04 сарын 01-ний өдрөөс эхлэн *www.ejob.gov.mn вэбсайтаар* дамжуулан иргэдэд түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэж байна. Уг цахим системд ажил хайгч иргэн хандсанаар өөрийн хөдөлмөр эрхлэх боломжийн үнэлгээг хийлгүүлэх, үүнд тулгуурлан ажил хөдөлмөр эрхлэх төлөвлөгөөгөө боловсруулах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө авах, | - | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 100.0 | холбогдох шаардлагатай дэмжлэг, туслалцааг цахимаар үнэ төлбөргүй авахаас гадна өөрийн ур чадвар, ажил, мэргэжилд нийцсэн ажлын байрны захиалгын дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авч ажилд зуучлагдах боломжтой болно. Нөгөө талаас ажил олгогч сул чөлөөтэй ажлын байрандаа өөрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ажилтныг зуучлуулан авах боломжтой програм юм.<br>-Мөн үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг бий болгох ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгээд байна.<br>**1**.Мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлж, ажилтнуудын ажлын ачааллыг бууруулах, төсөл, хөтөлбөрийг шинэчлэх, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтнуудын ажлын зохион байгуулалтыг өөрчлөн “Үйлчлүүлэгч төвтэй Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг” нэвтрүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд уг агуулга, үзэл баримтлалыг тусгасан. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, төсөл, хөтөлбөрийн арга хэмжээг цахимжуулах замаар үйлчлүүлэгч төвтэй Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүргэх юм. Энэ үүднээс ХЗЗМС-ийг шинэчлэн хөгжүүлэхээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.<br>**2.** Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг оновчтой удирдах болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, зохицуулалтын шийдвэр гаргахад статистик мэдээлэлд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй, ирээдүйд бий болох үр дүнгийн тооцоо, судалгаатай байх боломжийг ханган “Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ыг ашиглалтад оруулаад байна. Хөдөлмөр эрхлэлтийн динамик загварыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг туршин, халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хүрээнд Нийгмийн даатгалын болон Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлүүдийн тооцооллыг системийн динамик загварчлалын аргаар хийлээ. Тухайлбал Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх, Хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн олгоход нөлөөлөх эерэг болон сөрөг нөлөөлөл, ирээдүйн төсөөллийг тодорхойлох, оновчтой хувилбаруудыг турших ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>**3.**Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, төсөл, хөтөлбөрийн арга хэмжээг цахимжуулах замаар үйлчлүүлэгч төвтэй Хөдөлмөр эрхлэлтийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээг хүргэнэ. Энэ үүднээс Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэхээр ажлын хэсэг байгуулж, холбогдох төлөөллүүдийг оролцуулан саналыг авч, өнөөгийн 85 зураглал, ирээдүйн 72 зураглалыг гаргасан.<br>**4.** 14 аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст 2020-2021 онд үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний байр, танхимыг засварлан тохижуулж, оффисын тавилга хэрэгслээр хангасан ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс нийт 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. | | |
| | | 5 | Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээг ил тод, нээлттэй болгон цахимжуулна | 2020-2024 | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний удирдлага, зохицуулалтыг шинэчлэн үйл ажиллагааг цахимжуулсан байна. | 150.0 | Өмнөх жилүүдэд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувь, хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагын нийт монгол ажиллагчдын тоонд эзлэх хувь, хэмжээгээр тогтоодог байсныг дээрх хуулийн шинэчиллээр нийт гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тогтоохоор хуульчилсан. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Засгийн газар тогтооно" гэж заасны дагуу "Монгол Улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 359 дүгээр тогтоолыг батлуулсан.Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний зөвшөөрөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2020 онд эхлүүлж, цахим системийн хөгжүүлэлт хийгдэн, ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор ezuvshuurul.mn цахим хаяганд төвлөрүүлэн бүрэн ашиглалтад оруулан ажиллаж байна. Цахим шилжилттэй холбогдуулан шаардагдах дүрэм журмыг батлуулж, иргэд, аж ахуйн нэгжээс цахим системээр дамжуулан бичиг баримтыг хүлээн авч шийдвэрлэж байна. Мөн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний мэдээллийн сан үүсгэн, холбогдох мэдээ, мэдээллийг цаг алдахгүй цахим системд байршуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>Дээрх ажлын хүрээнд:<br>-"Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох журам"-ын 3.3, 3.4, 3.5, 3.6-д заасан | **19.6** | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээг 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ezuvshuurul системээр дамжуулан цахим хэлбэрээр үзүүлж байна.<br>-“Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгох“ үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, ezuvshuurul.mn/out цахим систем хөгжүүлэн бүрэн ашиглалтад оруулаад байна. Уг системд 68 тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй бөгөөд 2287 зуучлуулагч иргэн бүртгэлтэй байна.<br>-Ezuvshuurul.mn цахим систем нь ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой үйлчилгээг үзүүлэхээс гадна БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн Солонгос хэлний шалгалтын бүртгэлтэй холбоотой мэдээллийг цахимаар хүргэн ажиллах юм.<br>Улсын Их Хурлаар 2001 онд батлагдсан “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль”-ийг шинэчлэн найруулж “Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай” хууль нэрээр Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Уг хууль нь 2022 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжихтэй холбогдуулан цахим системд нэмэлт хөгжүүлэлт, засвар үйлчилгээ хийгдэнэ.<br>Гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах үйлчилгээний цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийх, засвар үйлчилгээний гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулахаар ажиллаж байна. Гэрээлсэн мөнгөн дүн 19.600.000 төгрөг болно.<br>Дараах ажлыг хийхээр төлөвлөж, ажлын даалгаврыг боловсруулж байна.<br>Үүнд:<br>-Гадаадад гаргах тусгай зөвшөөрлийн үйлчилгээний цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, засвар үйлчилгээ хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж байна. Ажлын даалгаварын дагуу гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулж, нэмэлт хөгжүүлэлт хийгдэнэ.<br>-Япон улсад ур чадвартай ажилтнаар илгээх цахим системийг нэвтрүүлж ezuvshuurul.mn хаяганд нэгтгэхээр төлөвлөж, ажлын даалгаварыг боловсруулж байна. Уг системийг гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 2.5.7.Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна. | 1 | Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ | 2020-2024 | Хуулийн төслийг батлуулсан байна. | - | Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой болгох, давхардлыг арилгаж халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай зорилтот бүлэгт тэтгэвэр, тэтгэмжийг чиглүүлэх үндсэн зарчмыг баримтлан Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчлэлийг боловсруулсан. Нөгөө талаар нийгмийн халамж болон хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг ялгаж, салгах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.<br>Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийн хүрээнд халамжийн хөтөлбөрүүдийг амьжиргаа багатай зорилтот хэсэгт чиглүүлэх, амьжиргааны түвшинтэй уялдуулах, өрх, иргэнийг чадавхжуулах, бие даан амьдралаа аваад явах чадвар дадлыг бий болгох, ажлын байранд бэлтгэх халамжаас хөдөлмөрт чиглүүлэх бодлогын шинэчлэлийг хийж Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой хуулийн төсөлд яамдаас дахин санал авч, хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Хуулийн төслийг боловсруулахад Дэлхийн банкны төслийн дэмжлэгтэйгээр зөвлөхүүд хамтран ажиллаж байна. | 18 сая төгрөг /Дэлхийн банкны төсөл/ | **70** |
| | | 2 | Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэх зорилгоор өрхийн амьжиргааны түвшинг төрийн байгууллагын мэдээллийн санд үндэслэн тодорхойлдог байхаар аргачлалыг шинэчлэн, нэвтрүүлнэ. | 2020-2024 | Шинэчлэгдсэн аргачлалын дагуу зорилтот бүлгийг тодорхойлж,нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан байна. | 600.0 | “Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”-ыг боловсруулах, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ХНХ-ын сайд, ҮСХ-ны даргын 2020 оны А/225, А/60 тоот хамтарсан тушаалаар байгуулан, аргачлалыг шинэчлэх ажлыг 2021-2022 онд хийж гүйцэтгэлээ. Аргачлалыг боловсруулахдаа 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг үндсэн мэдээлэл болгон ашиглан төрийн мэдээллийн санд байгаа, хууль, эрх зүйн орчны хүрээнд ашиглах боломжтой өрх, иргэний мэдээллийг регистрийн дугаараар холбон нэгдсэн мэдээллийн сан үүсгэсэн. Уг сан дээр загварын үнэлгээ, тооцооллыг олон хувилбараар үнэлж, гүйцэтгэлийг сайжруулж буй хувилбаруудыг нэгтгэн, шинэ загварыг боловсруулж, загварын үнэн бодит байдлыг шалган, эцсийн загварын төслийг боловсруулсан. Шинэчлэн боловсруулсан ООТА-ыг турших туршилтын судалгаанд хамруулах УБ хотын 6 дүүрэг, Орхон, Булган, Хэнтий, Дундговь аймгуудын 400 өрхийн мэдээллийг ҮСХ-нд | **183.8 сая** | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлж захиргааны мэдээллийг тулган, ТББ-тай хамтран судалгааны нарийвчилсан мэдээллийг цуглуулах ажлыг зохион байгуулсан. Дээрх үр дүнд үндэслэн үзэл баримтлал, аргачлал, маягт, нөхөх зааврыг шинэчлэн дахин хүргүүлж, ҮСХ-ны арга зүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, ҮСХ-ны дарга, ХНХ-ын сайдын 2022 оны А/84, А/89 хамтарсан тушаал батлагдсан. АХБ-ны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”- төслийн хүрээнд, Монгол Улсын нийт өрхийн амьжиргааг үнэлсэн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, мэдээллийн санг бүрдүүлэхэд ашиглах программ, аппликейшныг боловсруулахад дотоод зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна.<br>Монгол Улсын 2023 оны төсвийг УИХ-аар хэлэлцэж, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан. Уг төсөвт хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91 хувьд олгохоор шийдвэрлэсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар захирамжаар “*Төрийн байгууллагын мэдээллийн санг ашиглан хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг тодорхойлох*” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж холбогдох тооцоо, судалгааг хийж ажиллаж байна.<br>Үүний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/189 дугаар тушаалаар “Төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, програм хангамж хөгжүүлэх” Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг, “Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төсөл боловсруулах” Үндэсний статистикийн хорооны даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг тус тус байгуулсан.<br>Дэд ажлын хэсгүүд дараах ажлыг хийж байна. Үүнд:<br>- Үндэсний статистикийн дарга болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Дэлхийн банкны төлөөлөлтэй уулзаж, загварын тооцоололд гадаад зөвлөх авч ажиллуулах саналыг дэвшүүлж, дэмжлэг хүссэний дагуу 3 зөвлөх ажиллахаар болсон бөгөөд 2 зөвлөх Үндэсний статистикийн хороон дээр хүрэлцэн ирж ажиллаж байна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Шаардлагатай 150 гаруй үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, хүснэгтийн талбарыг боловсруулсан.<br>- Үндэсний статистикийн хороо өрхийн нийгэм, эдийн засгийн 2018, 2020 оны судалгааны 32 мянган өрх-иргэний мэдээллийг CD-нд буулгаж, төрийн байгууллагуудын нууцын ажилтнуудаар дамжуулан 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр бүх байгууллагуудад хүлээлгэн өгсөн.<br>- Төрийн нийт 14 байгууллагын 11 байгууллага нь мэдээллийг Үндэсний статистикийн хороонд гаргаж өгсөн. Үлдсэн Монголбанк, Орон сууц, нийтийн аж ахуй, хил хамгаалах ерөнхий газрууд мэдээллийг гаргаж өгөхөөр ажиллаж байна. | | |
| | | 3 | Цалинтай ээж" хөтөлбөрийг үргэлжлүүлж, 3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд ялгаварлалгүй олгоно. | 2020-2024 | - | - | Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хуулийг 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар батлан 2018 оноос хэрэгжүүлсэн.<br>Энэхүү хуулиар Цалинтай ээж буюу 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй ээжүүдэд сар бүр 50 000 төгрөг, гурав болон түүнээс дээш 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-д улирал бүр тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тэтгэмж олгох, жирэмсэн эх болон ихэр хүүхдэд тэтгэмж олгохоор зохицуулсан.<br>Уг хуульд 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж УИХ-ын нэгдсэн чуулганаар батлагдсанаар 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авч байсан эх хүүхдээ 3 нас хүрэхээс өмнө ажилд орсон тохиолдолд тэтгэмжийг хүүхдээ асарч байгаа эцэгт нь олгох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн. 2022 онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид нийт 188,0 орчим иргэн хамрагдаж 201,1 тэрбум төгрөг зарцуулав. | | **100** |
| | | 4 | Ахмад настны амьжиргааг дэмжиж, орлогын баталгааг хангах зорилгоор "Насны хишиг" тэтгэмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2020-2024 | 65 ба түүнээс дээш насны бүх ахмад настан бүрэн хамрагдсан байна. | 3,700.0 | Ахмад настны тухай хуулийн заасны дагуу Насны хишиг тэтгэмжийг 2017 оноос эхлэн жилд 2 удаа 65 ба түүнээс дээш настай ахмадуудад олгосон. Насны хишиг тэтгэмж нь ахмад настнуудын эрүүл насжих, тэдний орлогын баталгааг бууруулахгүй байхад чиглэсэн томоохон дэмжлэг болдог. 2022 онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 65 ба түүнээс дээш настай 168,2 мянган ахмад настанд 25.4 тэрбум төгрөгийн насны хишиг тэтгэмжийг олгов. | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 2.5.8. Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ. | 1 | Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг батлуулан гэр бүлийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчинг бий болгох, шинэ төрлийн үйлчилгээг бий болгож нэвтрүүлнэ. | 2021-2024 | Хуулийн хэрэгжилтийг хангаж, дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулсан байна. | - | Засгийн газраас 2021 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Гэр бүлийн тухай хуулийн төслийг эргүүлэн татсан бөгөөд 2021 оноос хойш уг хуулийн төслийг ХЗДХЯ хариуцан ажиллаж байна. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр ХНХСайд, ХЗДХСайдаар батлуулав.<br>Хуулийн төсөлд шинээр тусгах зарим асуудлын судалгааг хийсэн бөгөөд хуулийн төслийг төр, төрийн бусад байгууллага, олон нийт, хуулиар эрх ашиг нь хөндөгдөх хэсгийн төлөөллөөр нийт 4 удаа хэлэлцүүллээ. | | **100** |
| | | 2 | Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих асуудлаарх эрх зүйн орчныг шинэчилж, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | 2021-2024 | Хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох дүрэм журмыг батлуулсан байна. | 8,0 тэрбум | 1/ 2022 оны Төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.5-т "хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална" гэсэн нэмэлт орж батлагдсанаар хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг тооцох, санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалттай болсон. Уг заалтын дагуу "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"-ыг ХНХСайдын 2021 оны А/218 тушаал, "Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг төлөвлөх, санхүүжүүлэх аргачлал"-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>2/ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2022 оны 2-6 дугаар сард Засгийн газрын гишүүд болон олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулж, хуулийн төслийг эцэслэсэн. 2022 оны 09 дүгээр сард Засгийн газрын бүрэлдэхүүн шинэчлэгдсэн тул Хүүхэд хамгааллын тухай хуулийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар дахин шинэчлэн батлуулсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдан боловсруулсан хуулийн төслийг Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн. | | 90 |
| | | | | | | | -2022 оны 02 дугаар сараас Хүүхэд харах үйлчилгээ ХНХЯ-ны эрхлэх асуудалд шилжин ирсэнтэй холбогдуулан МУЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 97 тоот тогтоолоор “Хүүхэд харах | 1.3 тб төг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2.1 тэрбум | үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох” журам, ХНХ-ын сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/38 тоот тушаалаар “Хүүхэд харагч бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр”, ХНХ-ын сайдын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/151 дугаар “Журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам” шинэчлэн батлагдсан.<br>Түүнчлэн Засгийн газрын 2022 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд харах үйлчилгээний санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж байна.<br>Монгол Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд хүүхэд харах үйлчилгээний зардалд 2.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад батлагдсан бөгөөд энэ хүрээнд 2022 онд 1894 энгийн хүүхэд, 106 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдах тооцооллыг хийсэн.<br>Хүүхэд харах үйлчилгээг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж, улсын хэмжээнд 16 аймаг, 7 дүүрэгт 176 хүүхэд харах төвд 470 хүүхэд харагч ажиллаж, хамрагдсан нийт хүүхдийн дундаж 2200 байна.<br>-“Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын 6 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны А/145, А/261 дугаар хамтарсан тушаал баталж, нийслэлийн цэцэрлэгийн хүртээмж багатай Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, 2-3 настай 2000 хүүхдийг нэмж авахаар шийдвэрлэсэн. Шинээр 320 хүүхэд харагч 5 өдрийн сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн.<br>-2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хүүхэд харах үйлчилгээнд нийт 2239 хүүхэд үйлчлүүлж, Хүүхэд харах үйлчилгээний төв болон цэцэрлэгийн хүүхдийн давхардлыг шалган 303.460.806.4 төгрөгийн санхүүжилтийг төвүүдэд олгосон. Үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар арга зүйн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэмжлэг үзүүлж 10 зөрчил илрүүлж асуудлыг шийдсэн. | | |
| 3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ | 2021-2024 | Хуулийн хүрээнд холбогдох дүрэм журмыг боловсруулан батлуулсан байна. | - | "Саадгүй байдал, хүртээмжийн тухай" анхдагч хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийг төрийн бус байгууллагад 4 удаа хэлэлцүүлээд байгаа бөгөөд холбогдох Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг төрийн байгууллагын төлөөлөлд хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн явцад гарсан санал, зөвлөмжийг хуулийн төсөлд тусган ажиллалаа.<br>Үзэл баримтлалын төслийг холбогдох яамд руу хүргүүлэн батлуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.<br>Хуулийн төсөл нь 6 бүлэг, 21 зүйлтэй бөгөөд 1.Нийтийн тээврийн хүртээмж, 2.Барилга байгууламж, авто зам, замын байгууламжийн хүртээмж, 3.Мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж, 4.Үйлчилгээний хүртээмж гэсэн 4 төрлийн хүртээмжийн асуудлыг зохицуулах юм. | | **50** |
| 4 | Хүн амын амьдралын таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн Хүн амын хөгжлийн зорилтот хөтөлбөр, хүүхэд, залуучууд, ахмад настан, удмын сан, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | Хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний нэгдүгээр шатны /2022-2024/ хэрэгжилтийн төлөвлөгөөг сайдын тушаалаар баталж, хэрэгжилт 20-с доошгүй хувьд хүрсэн байна. | 2,100.0 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар Монгол Улс урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй байхаар заасан. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан. Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэхүйц байхаар тодорхойлж хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байхаар хуульчилсан. Дээрх хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийг ЭЗХ-ийн сайдын 2022 оны А/38 дугаар тушаалаар баталж, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах дэд ажлын хэсгийн ахлагчаар С.Зулпхар, нарийн бичгийн даргаар А.Хишигбаяр нар ажиллаж байна. НХЗХ-ийг төслийг танилцуулж, санал авах зорилгоор СЯ, ХХААХҮЯ, БХБЯ, ЭМЯ, ХЗДХЯ болон ХНХЯ-ны Хүн амын удирдлага, албан хаагчидтай уулзалт зохион байгууллаа. Мөн ЭЗХЯ-наас 2 удаа зохион | | **70** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх семинарт тус хөтөлбөрийг боловсруулах ажлын багийн бүрэлдэхүүн оролцлоо. Семинарын үеэр хөтөлбөрийн төслийг бусад хөтөлбөртэй уялдуулах, давхардал, хийдэгдлийг арилгах, хариуцах салбар байгууллага, хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг тодорхойлох чиглэлээр бусад хөтөлбөрийн ажлын хэсэгтэй хамтран ажиллалаа. Хөтөлбөрийн төслийг 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 7 дугаар сарын 5-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын намрын чуулганаар хэлэлцэж эхлээд байна. | | |
| | | 5 | Эрүүл, бүтээлч амьдрал, идэвхтэй, насжилтыг дэмжсэн, ахмад настанд ээлтэй, тэгш хүртээмжтэй урт хугацааны тусламж үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлнэ. | 2021-2024 | Төлөвлөгөөний хэрэгжилт 30-с доошгүй хувьд хүрсэн байна. | 300,0 | Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр аймаг, сум, нийслэлээс Сонгинохайрхан дүүрэгт “Ачлалт хүүхдүүд” ТББ, Дархан-Уул аймагт “Ахмадын хөгжлийн төв”, Сэлэнгэ аймгийн Мандал суманд Нэгдсэн эмнэлгийг түшиглэн 3 байршлыг сонгон хэрэгжүүлж эхлээд байна. Дээрх 3 байршилд санхүү, хүний нөөц, үйлчилгээний чанар, стратегийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дэмжих стратегиудыг танилцуулж, хэлэлцүүлэг хийж, шинээр гарч буй шаардлагатай стратеги чиглэлийг хамтран тодорхойлох зорилго бүхий сургалтыг үе шаттай зохион байгуулсан. Эрүүл мэндийн яамтай хамтран 3 зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны чиглэлтэй “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022 оны 6 дугаар сарын 27-ний өдрийн А/127, А/333 тоот хамтарсан тушаалаар батлуулав.<br>Тус төлөвлөгөөнд Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг 3 байршилд туршин нэвтрүүлэх юм. Энэ хүрээнд дээрх 3 байршилд санхүү, хүний нөөц, үйлчилгээний чанар, стратегийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дэмжих стратегиудыг танилцуулж, хэлэлцүүлэг хийж, шинээр гарч буй шаардлагатай стратеги чиглэлийг хамтран тодорхойлох зорилго бүхий сургалтыг зохион байгууллаа. Сонгосон 3 байршилд Идэвхтэй насжилтийг дэмжих төвийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэг сургалт зохион байгуулж, алсын хараа, зарчим, зорилт үйл | **АХБ KSTA (9928) төсөл** | **70** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааны чиглэлийг боловсруулан ажиллаж байна.<br>Төслийн явц, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал солилцохоор Азийн хөгжлийн банкны Тогтвортой хөгжил цаг уурын хөгжлийн газрын нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Мередит Вайз, Зүүн Азийн бүсийн газрын нийгмийн секторын ахлах мэргэжилтэн Раушанбек Маматкулов болон төслийн олон улсын зөвлөхүүд 2022 оны 10 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд манай улсад ажилласан.<br>Энэ хүрээнд ХНХЯ болон АХБ-ны төлөөлөл 2022 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд СХД-т “Ачлалт хүүхдүүд” ТББ, Дархан-Уул аймагт Ахмадын хөгжлийн төв, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт ажиллаж, “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийн үйл ажиллагаатай танилцаж, орон нутгийн төслийн удирдах хорооны ээлжит хурлыг зохион байгуулж, төслийн хэрэгжилт, тулгамдсан асуудал болон салбар дундын уялдааг хангахад чиглэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллалаа. Төслийн хүрээнд ХНХЯ, АХБ, олон улсын зөвлөхүүдтэй хамтран “Ахмад настны урт хугацааны тусламж үйлчилгээний шинэлэг тогтолцоог хөгжүүлэх нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. | | |
| | | 6 | Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлнэ. | 2021-2024 | Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн 70 хувьд урьдчилан сэргийлэх үйлчилгээ, хамгаалал шаардлагатай хүүхдэд хариу үйлчилгээг 100 хувь үзүүлсэн байна. | 2022 онд нийт батлагдсан төсөв 7.5 тэрбум төгрөг | -2022 онд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хүүхэд хамгааллын үйлчилгээг 77967 хүүхдэд, урьдчилан сэргийлэх үйлчилгээг 318900 хүүхдэд үзүүлсэн байна. Үүнд:<br>-14,207 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Харьяаллаар нь авч үзвэл: орон нутагт 10,842, нийслэлд 3,365 байна.<br>-Мөн Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын дагуу 3625 хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээ, 18843 хүүхдэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, 131906 хүүхдэд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлсэн байна.<br>-Улсын хэмжээнд 34 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр насанд хүрсэн 1299 хүчирхийллийн хохирогч, 2699 хүүхэд үйлчлүүлсэн. Нийт үйлчилгээ авсан хүүхдийн 116 нь 2-оос дээш удаа түр хамгаалах байранд ирсэн байна. Гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 1757, асрамж, халамжийн үйлчилгээнд 82, дэмжих, холбон | 4.8 тб.төг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зуучлах үйлчилгээг 860 хүүхдэд үзүүлж, аюулгүй байдлыг хангаж ажилласан. | | |
| | | | | | | | 1/ Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор нийт 1284 хүүхэд үйлчилгээ авсан. Үүнээс: Гэмт хэрэгт холбогдсон 191, гэмт хэргийн гэрч 179, гэмт хэргийн хохирогч 694, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 214, хорихоос өөр төрлийн ял авсан-1, Эрүүгийн хариуцлага хүлээсэн-5 хүүхдэд журмын дагуу үйлчилгээ үзүүлсэн. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран зохион байгуулж, хорооны гишүүдэд зориулсан арга зүйн гарын авлага 500 ширхэгийг хэвлэн түгээсэн.<br>2/ Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой нийт 116 гомдол, мэдээллийг хүлээн авч, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 110 зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэж 32,9 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна. Хүүхдийн эрхийн зөрчлийн 6 хэргийг шалгаж байна. | | |
| | | | | | | | 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 99204 дуудлага ирсний 58058 буюу 58.5 хувь нь зорилтот дуудлага эзэлж байна. Хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэргийн шинжтэй эрсдлийн түвшин дунд болон өндөр 8174 (нийт дуудлагын 8.2 хувь) дуудлагыг аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, сум, хорооны хамтарсан багт шилжүүлсэн байна. Кейс шийдвэрлэлт 66.7 хувьтай байна. Үлдсэн 33.3 хувь буюу 2722 нь хяналтанд хүүхэд хамгааллын үйлчилгээ авч байна. | | |
| | | | | | | | - Улсын хэмжээнд 21 байгууллагын 30 асрамж, халамжийн төвд 0-18 насны 974 хүүхэд, 19-21 насны 86 залуу нийт 1060 хүүхэд, залуус үйлчилгээ авч байна. Нийт хүүхдийн 8.1% нь буюу 86 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй.<br>- Гэр бүлтэй хүүхдүүдийг эргэн нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулж, 59 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсэн. Энэ нь 2021 онтой харьцуулахад 51.3%-иар өссөн үзүүлэлттэй байна.<br>2022 онд Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж, “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ын дагуу 10 асрамж халамжийн төвд 386 хүүхдийн хоолны хувьсах зардал олгосон. | | |
| | | | | | | | - "Хүүхэд хамгаалал-2022" нэгдсэн арга хэмжээний хүрээнд томоохон худалдаа үйлчилгээний төв, зах, дэлгүүр, гудамж талбай, авто угаалгын газар, орц хонгил, PC тоглоомын газар, хогийн цэг, мах нядалгааны газар гэх мэт нийт 348 газарт хяналт шалгалт явуулж, хууль тогтоомжийг сурталчлах, мөрдүүлэх шаардлага тавьж ажилласан.<br>- Хараа хяналтгүй 63 хүүхэд, хөдөлмөр эрхлэгч 59 хүүхэд, эцэг эхийн хараа хяналт сул 122 хүүхдэд үйлчилгээ үзүүлж, хяналт тавин ажилласан байна.<br>Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжийг иргэд, олон нийт, уяач, эцэг эхчүүдэд сурталчлан таниулах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан. Улсын хэмжээнд 2022 онд 06 сарын 01-ээс 8 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд 6704 хүүхэд уралдаанд оролцсон байна. Эдгээр уралдаанч хүүхдүүдээс 391 хүүхэд мориноос унаж, 22 хүүхэд хүнд бэртэл авсан бол 16 хүүхэд эмнэлгийн тусламж үйлчилгээ авч, 6 хүүхэд уралдааны үеэр нас барсан байна. | | |
| | | | | | | | -Хүүхэд, өсвөр үеийхэнд цагийг үр дүнтэй бүтээлч өнгөрүүлэх чиглэлээр 144 арга хэмжээнд 83,762 хүүхэд хамрагдсан.<br>-Хүүхдийг болзошгүй эрсдэлээс болон /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 588 удаагийн арга хэмжээнд 96528 хүүхэд, 105352 насанд хүрэгч, хүүхэд, гэр бүлд чиглэсэн нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг 27715 хүүхдэд үзүүлсэн байна. | | |
| | | 7 | Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн | 2021-2024 | Гэр бүл, хүүхэд, залуучууд ахмад настны хөгжлийн цогц төвийн үйлчилгээг нийт хүн амын 10-с доошгүй | 803,9 сая төг | Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийг дэмжих чиглэлээр шинээр 5, шилжих 12 барилга байгууламж барихаар 24,6 тэрбум төгрөгийг тусган батлуулсан. | 482,0 сая.төг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ | | хувьд хүргэсэн байна. | | Хүн амын бүлэгт чиглэсэн төвүүдээр дараах үйлчилгээг үзүүлж байна. Үүнд: Залуучуудын хөгжлийн төв 21 аймаг, 9 дүүрэг, 5 сум (Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Номгон, Булган)-д ажиллаж, амьдрах ухааны сургалт, сонирхлын клуб, зөвлөлийг ажиллуулах, хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ, тусламж, гэр бүлийн зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, зөвлөгөө, зуучлалын үйлчилгээнд жилд дунджаар нийт залуучуудын 40 хувийг хамруулдаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 450 мянга гаруй залуучууд буюу нийт залуучуудын 45 хувьд хөгжлийн үйлчилгээг хүргэсэн. Мөн Ховд аймгийн Манхан сум, Баян-Өлгий аймгийн Сагсай сум, Завхан аймгийн Их-Уул суманд Залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулаад байна. | | |
| | | | | | 346.5 сая | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн гэр бүлийн боловсрол олгох сургалтад 88431 иргэнийг, "Хүмүүжлийн эерэг арга" сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 47300 иргэн, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 39065 иргэн угийн бичгийн сургалтад 12421 иргэнийг тус тус хамруулсан байна. | 221,8 сая.төг | |
| | | 8 | Хүүхдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөгжлийн үйлчилгээг хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. | 2021-2024 | Найрамдал-2 зуслангийн барилгын ажлын 60 хувийг гүйцэтгэсэн байна | Өвлийн байрны барилгын ажлын Нийт төсөвт өртөг: 30,000,000,000 (Гучин тэрбум) төгрөг | Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн "Олон улсын хүүхдийн "Найрамдал-2" зуслан байгуулах тухай 205 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд тус зусланг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгоны нутаг дэвсгэрт Хөвсгөл нуурын эрэгт нийт 60 га талбайд байгуулахаар төлөвлөсөн. Зуслангийн зураг төсөл боловсруулах ажлыг БХБЯ-наас зохион байгуулж шалгарсан компанитай хамтран ажилласнаар зураг төслийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. ХНХЯ-ны ТНБД-ын 2022 оны А/23 дугаар тушаалаар "Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслангийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги" боловсруулах зөвлөхүүдийг сонгон шалгаруулж, хөгжлийн стратегийн төслийг боловсруулсан.<br>-Олон Улсын Хүүхдийн Найрамдал-2 цогцолбор /Хөвсгөл, Хатгал сум/-ын төсөл арга хэмжээний Өвлийн байрны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр зарлаж, 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Тендерт | 0 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцох сонирхсон этгээд тендер ирүүлээгүй үндэслэлээр хүчингүй болсон.<br>2/ Улсын хэмжээнд 2022 онд 38 хүүхдийн зуслан үйл ажиллагаа явуулж, 34042 хүүхдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулсан байна.<br>3/ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/854 тоот захирамжийн дагуу нийслэлийн ногоон бүсийн хүүхдийн зусланд зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуслангийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж 350 хүүхдийг амраалаа.<br>Тайлбар: Хөгжлийн бэрхшээлтэй 60 хүүхдийг асран хамгаалагчийн хамт хүүхдийн Анар зусланд хөгжлийн хөтөлбөрт хамруулж, нийт 21 сая төгрөгийг зарцуулсан. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт 2022 онд нийт 154,643,500 төгрөгийн дэмжлэг 17 зусланд үзүүлсэн. | | |
| | | 9 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг нэвтрүүлнэ. | 2021-2024 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвүүдийн барилгын ажлыг бүрэн дуусгасан байна. | 4,360.0 | АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажил Архангай, Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул аймагт хийгдэж байна. Архангай аймаг 42%, Ховд аймаг 87%, Дорнод аймаг 77%, Дундговь аймаг 82%, Дархан-Уул аймаг 82%, Хөвсгөл аймаг 95 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Улаанбаатар хотод барих Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын зураг, төсвийг 2021 оны 12 дугаар сард батлуулсан. Тус төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалтын дотоодын тендерийг 2022 оны 2 дугаар сард зарлаж, гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулж, барилга угсралтын ажлыг 2022 оны 06 дугаар сард эхлүүлэв.<br>“Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор барих төсөл”-ийн барилгын ажлыг эхлүүлэх, солилцох захидлын төслийг боловсруулж, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнүүдийг холбогдох байгууллагуудаар хийлгэж, БНХАУ-ын талд хүргүүлээд байна. 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хуралдсан Монгол Хятадын Засгийн газар хоорондын комиссын 17 дугаар хуралдаанаар хэлэлцсэн ажлын төлөвлөгөөнд солилцох | 6.011,0 | 50 |
| | | | | 2021-2024 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгын ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна. | 1,940.0 | | - | 30 |
| | | | | 2021-2024 | Спорт цогцолборын барилгын ажлыг эхэлсэн байна. | 25,000.0 | | - | **30** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | захидлыг байгуулах ажлыг эрчимжүүлэх талаар санал тусгуулав. | | |
| 9 | 2.5.9.Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 1 | Орлого багатай өрхийн гишүүдэд мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлнэ. | 2020-2024 | Хөтөлбөр, төслийг хэрэгжүүлсэн байна. | 1,000.0 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 11-ны өдрийн 01 тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийн дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлтийг оруулж, шинээр “Ногоон ажлын байр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг баталж 2022-2023 онд хэрэгжүүлэхээр баталсан.<br>Дээрх хөтөлбөрүүдийг энэ онд хэрэгжүүлэхэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 59.7 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөсөн.<br>2022 оны жилийн эцэст хүлээгдэж байгаа дүнгээр: Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 11112 иргэн хамрагдаж, 1224 иргэн ажлын байраар хангагдаж, 601,943,740 төгрөгийг зарцуулсан байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл:<br>• Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтап 5,895 иргэн хамрагдаж, 535 ажлын байр бий болж, 159,140,000 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Ажилд зуучлах уулзалтад бэлтгэхэд 3374 хүн хамрагдаж 583 хүн ажлын байраар хангагдаж, 140,806,840 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Танхимын сургалтад 1843 хүн хамрагдаж, 106 хүн ажлын байраар хангагдаж 301,906,900 төгрөгийг тус тус зарцуулсан Цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжиж иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.<br>2. Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 9095 иргэн хамрагдаж 18,294,307,686 төгрөг зарцуулж 3764 ажлын байр бий болсон байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:<br>• Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2032 иргэн хамрагдаж, 2263 ажлын байр | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бий болж, 13,858,925,500.00 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 3618 иргэн хамрагдаж, 68,408,500.00 төгрөгийн санхүүжилт гарсан байна.<br>• Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 702 өрхийн 1704 иргэн хамрагдаж, 1452 ажлын байр бий болж, 3,801,693,920.00 төгрөгийг;<br>Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 14 өрхийн 28 иргэн хамрагдаж 52,365,994.00 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт зохион байгуулах арга хэмжээнд 492 өрхийн 624 иргэн хамрагдаж 20,446,301 төгрөгийг зарцуулсан байна.<br>- Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 915 иргэн хамрагдаж 170,531,521 төгрөгийг;<br>3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт, 11048 иргэн хамрагдаж, 738,478,606.00 төгрөгийг зарцуулж 4771 ажлын байр бий болсон байна.<br>• Ажлын дадал туршлага эзэмшүүлэх үйлчилгээнд 4203 иргэн хамрагдаж 80,510,190.00 төгрөг зарцуулж 267 иргэн ажлын байртай болсон байна.<br>• Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулах арга хэмжээнд 150 иргэн хамрагдаж, 40,317,000 төгрөг зарцуулсан байна.<br>• Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 291 баг, 687 иргэн хамрагдаж 155,535,030.00 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Гарааны санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 24 багийн 46 иргэн хамрагдаж, 240,000,000.00 сая төгрөг зарцуулж, 48 ажлын байр бий болсон байна.<br>• Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд сургалт зохион байгуулахад 1066 иргэн хамрагдаж 53,074,750.00 төгрөгийг;<br>• Цагийн ажилд зуучлах арга хэмжээнд өссөн дүнгээр нийт 4896 иргэн хамрагдаж 22,932,636.00 төгрөг зарцуулж 4456 иргэн ажлын байраар хангагдсан байна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • Мөн Улсын хэмжээний Старт-ап шалгаруулах арга хэмжээний хүрээнд 145,926,000 төгрөг зарцуулагдсан байна.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр: 3163 иргэн хамрагдаж 6,934,748,890.00 төгрөгийг зарцуулж 1031 ажлын байр бий болсон байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 48 иргэн хамрагдаж, 108,498,390.00 төгрөгийг зарцуулж 16 иргэн ажилд зуучлагдсан байна.<br>• Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 868 иргэн хамрагдаж, 905 ажлын байр бий болж, 4,825,000,000.00 төгрөгийг;<br>• Төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 21 төрийн бус байгууллага хамрагдаж 21 ажлын байр бий болж 280,000,000 төгрөг зарцуулсан байна.<br>• Аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 23 төрийн бус байгууллага хамрагдаж 51 ажлын байр бий болж 765,000,000 төгрөг зарцуулсан байна.<br>• Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 171 иргэн хамрагдаж 20,827,050.00 төгрөгийг;<br>• Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 43 иргэн хамрагдаж, 42,678,800.00 төгрөгийг,<br>• Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 1738 иргэн хамрагдаж 40,527,900.00 төгрөгийг;<br>• Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 210 иргэн хамрагдаж, 33 ажлын байр бий болж, 53,246,700.00 төгрөг зарцуулсан байна.<br>• Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 13 ажил олгогч хамрагдаж 18 иргэн ажлын байраар хангагдаж 70,560,000.00 төгрөгийн санхүүжилт тус тус гарсан байна.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд 728,410,050 төгрөгийг зарцуулсан байна.<br>4.Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт: Өссөн дүнгээр нийт 1616 ахмад | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжилтэн хамрагдаж 4,613,836,510.00 төгрөг зарцуулж, 1580 ажлын байр бий болсон байна.<br>5.Ногоон ажлын байр хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны 10 сарын байдлаар өссөн дүнгээр харуулвал 14862 иргэн хамрагдаж 4,587,702,213.00 төгрөгийг зарцуулж 14,862.00 ажлын байр бий болсон байна. | | |
| | | 2 | Хүн амын бүлгүүд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэх болон бусад үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ. | 2020-2024 | Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 19,100.0 | Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангахад хөтөлбөрийн зорилго оршино.<br><br>Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцэст хүлээгдэж байгаа дүнгээр: харуулвал 9156 иргэн хамрагдаж, 732 иргэн ажлын байраар хангагдаж, 487,183,100 төгрөгийг зарцуулсан байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл:<br>• Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтап 4391 иргэн хамрагдаж, 402 ажлын байр бий болж, 121,928,000 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Ажилд зуучлах уулзалтад бэлтгэхэд 3057 хүн хамрагдаж 237 хүн ажлын байраар хангагдаж, 88,081,200 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Танхимын сургалтад 1708 хүн хамрагдаж, 93 хүн ажлын байраар хангагдаж 277,173,900 төгрөгийг тус тус зарцуулсан байна.<br>Түүнчлэн ажилгүй болон нийгмийн халамжийн үйлчилгээ авдаг хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай 50,000 иргэнд **профайлинг буюу хөдөлмөр эрхлэх ур чадварыг үнэлэх** ажлыг зохион байгуулж байна. Ингэснээр тэдний онцлог хэрэгцээг тодорхойлж тохирсон ажил, үйлчилгээг санал болгож, ажлын байраар хангах боломж бүрдэх юм. | 13.6 | **100** |
| 12 | 2.5.12.”Хуримтл алтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь | 1 | Хүүхэд бүрд хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд | 2021-2024 | - | 148,800,0 | Монгол Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг 2021 оны 11 сард баталж, Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд мөнгөн хуримтлал үүсгэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлсэн.<br>Ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ. | | зарцуулах дэмжлэг олгоно. | | | | уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан "Хуримтлалтай Монгол хүүхэд" хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлж эхлэв. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор "Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам"-ыг баталсан. 2022 оны 10 дугаар сарын байдлаар 23909 хүүхдэд 3.0 тэрбум төгрөгийн мөнгөн хуримтлал үүсгэсэн байна. Харин хүүхдийн мөнгөн хуримтлалаас дунджаар 1,234.175 хүүхдэд 100.0 мянган төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгоход 1,234.1 тэрбум төгрөг зарцуулсан байна. | | |
| 13 | 2.5.13.Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | 1 | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ | 2020-2024 | Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан байна. | - | -Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс "Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ" гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.<br>-Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>-Өргөн мэдүүлсэн хуулийн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.13-д "Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс төлнө” гэж тусгасан. | | |
| 14 | 2.5.14 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 1 | Эдийн засгийн загварчлалд суурилсан бүтээн байгуулалт, салбар дундын зохицуулалтыг бий болгож, тогтолцоог хөгжүүлнэ. | 2020-2024 | Загварчлалд суурилсан зохицуулалтыг бий болгосон байна. | 200.0 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг удирдах болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, зохицуулалтын шийдвэр гаргахад шинжлэх ухааны үндэслэл, тооцоо, судалгаатай байх боломжийг бүрдүүлэхэд анхаарч, ОУШХБ-ын дэмжлэгтэйгээр системийн динамик загварыг боловсруулж, туршилтаар ажиллуулж эхлээд байна. “Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын шийдвэр гаргахад ашиглахаас гадна үндэсний хэмжээний хөгжлийн бодлого, төлөвлөлт, салбар дундын болон бүс нутгийн хэмжээнд шийдвэр гаргахад ашиглах бүрэн боломжтойгоороо ач холбогдолтой юм.<br>Хөдөлмөр эрхлэлтийн динамик загварыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг туршин, халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хүрээнд Нийгмийн даатгалын болон Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлүүдийн тооцооллыг системийн динамик загварчлалын аргаар хийлээ. Тухайлбал Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх, Хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн олгоход нөлөөлөх эерэг болон сөрөг нөлөөлөл, ирээдүйн төсөөллийг тодорхойлох, оновчтой хувилбаруудыг турших ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Цаашид энэхүү динамик загварыг Монгол Улсын эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн төлөвийг тодорхойлон бодлого, шийдвэр гаргахад ашиглахаас гадна их дээд сургуулийн багш, оюутан, эрдэм шинжилгээний байгууллагын судлаач, иргэдэд нээлттэй байдлаар ашиглах боломжийг бий болгохоор зорин ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн динамик загварыг хөгжүүлэх, үйл ажиллагааг цаашид хариуцан ажиллах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын баг хамт олонд уг загвараар тооцсон зарим туршилтын үр дүнг танилцуулан, загварыг хүлээлгэн өгөх арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт загварыг хөгжүүлсэн зөвлөх багтай хамтран ажиллан хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик тоон мэдээлэл болон загварын тооцооллын нарийвчлалыг | | **70** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайжруулахаар ажиллаж байна. Загвар хөгжүүлэлтийн хүрээнд динамик загвараар симуляци хийхэд нэн шаардлагатай байгаа дараах мэдээллүүдийг тулгах, нарийвчлах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>***Нийгмийн хамгааллын тооцоолол, хөгжүүлэлт:*** Өрхийн орлогын тоон мэдээлэл;<br>***Нийгмийн даатгалын*** тооцоолол ***хөгжүүлэлт:*** Тэтгэвэр, даатгуулагч, цалинтай холбоотой тоон мэдээллүүд;<br>***Хөдөлмөр эрхлэлтийн тооцоолол хөгжүүлэлт***: Ажилчдын тоон мэдээллийг сайжруулах зэрэг ажлуудыг хийлээ.<br>Хөдөлмөр эрхлэлтийн динамик загварыг хөгжүүлэх жишиг ажлын даалгаврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/103 дугаар тушаалаар батлан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн. | | |
| | | 2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдэд олгох жижиг зээлийн хэмжээг нэмэгдүүлж, хугацааг уртасган хүртээмжийг нэмэгдүүлэх | 2020-2024 | Зээлд 1600-аас доошгүй иргэн хамрагдаж, 3000-аас доошгүй ажлын байр бий болсон байна. | 10.200,0/ ДБ-ны санхүүжилтээр/<br>20,000.0 /ХЭДС/ | Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.<br>Одоогийн байдлаар “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний хүрээнд бичил бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх ур чадвахыг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, цаашид тогтвортой хадгалах зорилгоор жижиг зээлийг олгож байна. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд гэрээ байгуулсан хугацаанаас хойш Хаан банк, Төрийн банкаар дамжуулан 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 1402 иргэнд 12,5 тэрбум төгрөгийн зээлийг олгож нийт 2740 ажлын байрыг бий болгосон байна. | **12.400,0 /өссөн дүнгээр/** | **90** |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны төсвийн хуваарьт жижиг зээлд зориулан 20,0 тэрбум төгрөг төсөвлөсөн ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг дамжуулан олгох банкийг сонгон шалгаруулах удирдамж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг дамжуулан олгох банктай байгуулах гэрээний загварыг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/93 дугаар тушаалаар баталсан. | | |
| | | 3 | Зорилтот бүлгийн иргэдийн хувиараа аж ахуй, гарааны бизнес эрхлэхийг дэмжих зорилгоор хүүгүй, барьцаагүй, эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг болон бусад шинэ арга дэмжлэгийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2020-2024 | Жил бүр санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж, зээлд 4500-с доошгүй иргэн хамрагдаж, 6000-с доошгүй ажлын байр бий болсон байна. | 24,000.0 | Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 2022 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр нийт 9095 иргэн хамрагдаж 18,294,307,686 төгрөг зарцуулж 3764 ажлын байр бий болсон байна. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2032 иргэн хамрагдаж, 2263 ажлын байр бий болж, 13,858,925,500.00 төгрөгийг зарцуулсан байна. Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 702 өрхийн 1704 иргэн хамрагдаж, 1452 ажлын байр бий болж, 3,801,693,920.00 төгрөгийг зарцуулсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр харуулвал 3163 иргэн хамрагдаж 6,934,748,890.00 төгрөгийг зарцуулж 1031 ажлын байр бий болсон байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 48 иргэн хамрагдаж, 108,498,390.00 төгрөгийг зарцуулж 16 иргэн ажилд зуучлагдсан байна.<br>Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 868 иргэн хамрагдаж, 905 ажлын байр бий болж, 4,825,000,000.00 төгрөгийг зарцуулсан байна. | **185.9** | **90** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | 2.5.15.Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно. | 1 | Гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эх орондоо эргэн ирж, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх эрхзүйн үндсийг бүрдүүлнэ. | 2020-2024 | Хууль эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд өөрчлөлт оруулж батлуулсан байна. | - | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн чуулганаар эцэслэн баталсан бөгөөд хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хуулийн 20 дугаар зүйлд “Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх” тухай заалтыг тусгаж, санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, холбогдох Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан.<br>Мөн Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ийг шинэчлэн баталсан. Журмын 2.2-т зээл хүсэгч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан иргэн, аж ахуйн нэгж байх бөгөөд нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн нь байгуулж буй нөхөрлөл, хоршоогоо Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхээр<br>мэдүүлсэн иргэдийн эрх бүхий төлөөлөгч, гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн нь гадаад улсад суралцахаас бусад зорилгоор ажиллаж, амьдарч байгаад эх орондоо буцаж ирээд 48 хүртэл сар болж байгаа иргэн байх бөгөөд 25 хүртэлх сая төгрөг байна.<br>“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн 2019-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.2-д тусгасан Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх, E-job платформыг нэвтрүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг энэ оны байдлаар 10 удаа, системийн дизайн хөгжүүлтэд санал өгөх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний процессын зураглалыг шинэчлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг 6 удаа, шаардлагатай бусад уулзалт хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулж, систем хөгжүүлэлтэд бүртгэл мэдээллийг хэрхэн сайжруулах талаар саналыг тусгасан. E-job платформыг нэвтрүүлэх ажил 2022 оны 11 дүгээр сард дуусгав. Мөн эх орондоо эргэн ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Хөдөлмөрийн яармагийг энэ оны сүүлийн хагас | | **100** |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | жилд Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна. | | |
| | | 2 | Гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эх орондоо эргэн ирж, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх эрхзүйн үндсийг бүрдүүлнэ | 2020-2024 | **Хөдөлмөрийн биржийг байгуулж, үйл ажиллагааг туршилтын байдлаар хэрэгжүүлж эхэлсэн байна.** | 500.0 | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн чуулганаар эцэслэн баталсан бөгөөд хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хуулийн 20 дугаар зүйлд “Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх” тухай заалтыг тусгаж, санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, холбогдох Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн А/162 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцоо, судалгаа бусад баримт бичгийн хамт боловсруулсан. Түүнчлэн 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, Хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөгийн жижиг зээл олгохоор тусгасан.Мөн Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ийг шинэчлэн баталсан. Журмын 2.2-т зээл хүсэгч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан иргэн, аж ахуйн нэгж байх бөгөөд нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн нь байгуулж буй нөхөрлөл, хоршоогоо Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхээр<br>мэдүүлсэн иргэдийн эрх бүхий төлөөлөгч, гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн нь гадаад улсад суралцахаас бусад зорилгоор ажиллаж, амьдарч байгаад эх орондоо буцаж ирээд 48 хүртэл сар болж байгаа иргэн байх бөгөөд 25 хүртэлх сая төгрөг байна. | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн 2019-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.2-д тусгасан Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх, E-job платформыг нэвтрүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг энэ оны байдлаар 10 удаа, системийн дизайн хөгжүүлтэд санал өгөх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний процессын зураглалыг шинэчлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг 6 удаа, шаардлагатай бусад уулзалт хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулж, систем хөгжүүлэлтэд бүртгэл мэдээллийг хэрхэн сайжруулах талаар саналыг тусгасан. **E-job платформыг нэвтрүүлэх ажил 2022 оны 11 дүгээр сард дуусаад байна. Мөн эх орондоо эргэн ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Хөдөлмөрийн яармагийг энэ оны сүүлийн хагас жилд Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна.** | | |
| 16 | 4.2.5.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | 3 | Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2021-2024 | Сургалт, сурталчилгааг явуулсанаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна. | - | Яам, харьяа байгууллагын төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, 2020 оны “Журам батлах тухай” 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын холбогдох заалтыг хэрэгжүүлэхдээ албан хаагчийг хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байх шалгуурыг хангасан эсэхийг үндэслэл болгож байна.<br>Тус яам Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”-д нийцүүлэн Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/129 дүгээр тушаал, 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/85 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг, Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/168 дугаар тушаалаар “Хөдөлмөр, | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийгмийн хамгааллын яамны Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"-ыг тус тус шинэчлэн баталсан бөгөөд сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг Ёс зүйн зөвлөлийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн хүрээнд "Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага" "Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь" дэд төслүүдийг 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хэрэгжүүлэхээр шалгарсан. Дэд төслүүдийг хэрэгжүүлэх замаар төслийн туршин нэвтрүүлэлтийн үр дүнг бэхжүүлэх, сургагч багш нарыг бэлтгэх, төрийн байгууллагын үр дүнг дэмжих хүний нөөцийн удирдлагыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, Сонгон шалгаруулалт, Гүйцэтгэлийн удирдлага, Сургалт хөгжил гэсэн чиглэлээр төлөвлөгөөт ажлууд хийхээр зорин ажиллаж байна.<br>Тус дэд төслийн хүрээнд Төрийн албаны мөн чанар, төр нийтийн ашиг сонирхолд ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах нийцлийн болон шударга ёсны хандлага, төрийн албан хаагчийн шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлс зэргийг танилцуулж, ёс зүйн чиг баримжааг бүтээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор төрийн албанд томилогдоод 1-3 жил ажиллаж байгаа албан хаагчдад "Шинэ томилогдсон албан хаагчийн шударга, зарчимч байдлыг нэмэгдүүлэх нь" хэлэлцүүлэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сонгон шалгаруулалт, тусгай шалгалт авахад оролцоотой ажилладаг албан хаагчдад "Үр дүнд суурилсан Албан тушаалын тодорхойлолт боловсруулах", "Чадамжид суурилсан ярилцлага хийх" талаар чадавхжуулах сургалт, Хэнтий аймаг дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын албан хаагчдад "Төрийн албаны ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулаад байна. | | |
| 17 | 4.2.11.Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн | 1 | Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, хилийн | 2021-2024 | Гадаадад ажиллаж амьдарч буй | | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит Чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин | | **90** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ирж ажиллах, хилийн чанадаас улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. | | чанадаас улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. | | иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, таатай нөхцлийг бүрдүүлнэ. | - | төгөлдөр мөрдөгдөж байна. Хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлд “Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх” тухай тусган батлуулсан. | | |
| 18 | 4.3.5.Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ. | 2 | Эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2021-2024 | Төлөвлөгөө батлагдахаас өмнөх оны байдлыг төлөвлөгөө батлагдсанаас хойших хэрэгжилттэй харьцуулан үр дүнг тооцно. | 234,5 сая.төг | Тус яам нь 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс БНСУ-ын Гэр бүл, Жендэрийн эрх тэгш яамтай хамтран “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх үйлчилгээг бэхжүүлэх” төслийг 5 жилийн хугацаатай 750 000 USD (долоон зуун тавин мянган ам доллар)-ын санхүүжилттэй хэрэгжүүлж байна. Төслийн гол зорилго нь Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, эмэгтэйчүүд, охидыг эргэн нийгэмшүүлэх, эдийн засгийн хувьд нөхөн сэргээх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Энэхүү төслийг Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд Хүйсийн тэгш эрх төвд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт 2020 онд 46 хохирогч, 2021 онд 41 хохирогч, 2022 оны 11 сарын байдлаар 45 хохирогч хандаж анхан шатны (хамгаалах байрны үйлчилгээ, гадаад оронд хүний найманы хохирогч болсон Монгол улсын иргэдийг эх нутаг нь эгүүлэн авчрах, эрүүл мэнд, хоол хүнс, нэг удаагийн хувцас, ахуйн хэрэглээний үйлчилгээ, хууль зүйн туслалцаа болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх гэх) болон нөхөн сэргээх (сэтгэл засал, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, өмгөөллийн туслалцаа, гэр бүлд нэгтгэх, ажил зуучлах, гэх) үйлчилгээнд хамрагдсан байна. Үүнээс :<br>-10 хохирогчийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, хамгаалах байрны үйлчилгээ<br>-41 хүнд сэтгэл зүй, хууль зүйн анхан шатны туслалцаа, хоол хүнс, хувцас, ахуйн хэрэглээний туслалцаа;<br>-Зорилтот 4 бүлгийн (нийгмийн ажилтан, хууль сахиулах, зочид буудлын үйлчилгээний ажилтан нар) 2714 мэргэжилтнүүдэд хүн худалдаалах гэмт хэрэг, жендэрт суурилсан хүчирхийлэл, хохирогчид | 192,3 сая.тө | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах талаарх мэдээлэл;<br>-Мөн зорилтот бүлгийн 714 хүнийг сургалтад;<br>-Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 ном<br>-1 плакатыг 3300 ширхэг хэвлүүлж, олон нийтэд түгээгээд байна.<br>-Олон нийтэд мэдээлэл өгөх компанит ажлыг (Street company) Эрүүгийн Цагдаагийн албатай хамтран Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Улаанбаатар хотод зохион байгуулж, эцэг эхчүүд болон хүүхдүүдэд хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл өглөө.<br>-Хүн худалдаалах хохирогчийг таних, илрүүлэх зааврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | |
| **Нийт арга хэмжээний биелэлт 85.9%** | | | | | | | | | |

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ